

САЙНЦАГААН СУМЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮСЭД ДАГАЖ МӨРДӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Дундговь аймгийн төв Сайнцагаан сумын агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх дэглэм, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээг тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэ журмыг Сайнцагаан сумын агаарын чанарыг сайжруулах бүсэд ажиллаж, амьдарч байгаа иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

Хоёр. Агаарын чанарыг сайжруулах бүсэд хэрэгжүүлэх арга хэмжээ

2.1. Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгж байгууллагууд нь агаар бохирдуулагч аливаа эх үүсвэр ашиглаж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ Ус, цаг уур, орчны шинжилгээний төвөөр дүгнэлт гаргуулан Сайнцагаан сумын Засаг даргаас зөвшөөрөл авна.

2.2 Угаарын хийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор түр болон байнгын оршин суугч гэр хорооллын айл өрхүүдэд яндангаа хөөлөх, зуухаа сайжруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, сурталчилах;

2.3. Дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд зуухны яндандаа шүүлтүүр суурилуулах;

2.4. Дугуй засвар, харуулын байр, автомашины засвар, угаалгын газрууд зориулалтын бус түлш буюу хаягдал дугуй, ашигласан тос масло, хуванцар болон нийлэг уут гэх мэт хог хаягдлыг шатаахгүй байх;

2.5. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд иргэн 3-аас доошгүй, аж ахуй нэгж байгууллагууд 10-аас доошгүй мод бутыг өөрийн эзэмшлийн талбайд тарьж, ургуулах, бүх нийтийн мод тарилтын үйл ажиллагаанд идэвхи, санаачлагатай оролцох;

2.6. Айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжүүд хог хаягдлаа ангилан ялгаж хэвших;

2.7. Гэр хорооллын айл өрхүүд ариун цэврийн байгууламжийг “Нүхэн жорлон, угаадасны нүх” техникийн шаардлага MNS 5924:2015 стандартад нийцүүлэх;

2.8. Агаарын чанарыг сайжруулах бүсэд орших айл өрх, аж ахуйн нэгж байгууллагууд өдөр, шөнийн 2 тарифт тоолуур суурилуулж, цахилгаан эрчим хүчний хөнгөлөлтөд хамруулах;

2.9 Байшин, барилгын дулаан алдагдлыг багасгах үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлэх

Гурав. Төрийн байгууллагуудын чиг үүрэг

3.1. Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг дарга энэхүү журмын хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна;

3.2. Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана;

3.3. Багийн Засаг дарга нар агаарын чанарыг сайжруулах бүсэд орших айл өрх болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуй нэгж байгууллагын бүртгэлийг гаргаж, дүн мэдээг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвд хүргүүлнэ;

3.4. УЦУОШТөв нь агаарын чанарыг сайжруулах бүсэд орших агаар бохирдуулах эх үүсвэрийн мэдээлэл болон агаарын чанарын төлөв байдлын талаарх тайлан мэдээг Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газарт тус тус хүргүүлнэ;

3.5. Өвлийн улиралд бага насны хүүхэд, жирэмсэн эхчүүд, өндөр настнуудад агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөлөөс эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх, зөв дадал, хэрэглээг хэвшүүлэх сурталчилгааг Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газар, Сумын Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулна;

Дөрөв. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх үүрэг

4.1. Агаарын чанарыг сайжруулах бүсэд орших иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд Агаарын тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1. Мэргэжлийн хяналтын болон цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч, байгаль орчны мэргэжилтнийг шаардлагатай тохиолдолд өөрийн эзэмшилд нэвтрүүлж, түүний тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

4.1.2. Агаарын бохирдлын сөрөг нөлөөллөөс эрүүл мэндээ хамгаалах зорилгоор дотоод орчны агаарын чанараа сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

4.1.3. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр зохион байгуулж байгаа сургалт, сурталчилгаанд оролцох;

4.1.4. Агаар хамгаалах талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах;

4.1.5 Энэхүү журмын 2.4-д заасан зөрчил гаргасан иргэн, аж ахуй нэгж байгууллагыг холбогдох байгууллагад тухай бүр мэдээлэх;

4.1.6 Агаарын чанарыг сайжруулах бүсэд хэрэгжүүлэх арга хэмжээг мөрдөж ажиллах;

4.1.7. Хуульд заасан бусад эрх, үүрэг;

Тав. Хяналт тавих

5.1 Энэхүү журмын хэрэгжилтэд Дундговь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, сум, багийн Засаг дарга нар хяналт тавина.

Зургаа. Хариуцлага

6.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

Сайнцагаан сумын агаарын чанарыг сайжруулах бүс

| Агаарын чанарыг сайжруулах бүс | Бүсэд хамрагдах газрын байршил, багууд | Гэр хорооллын айл өрх | Орон сууцны айл өрх |
|--------------------------------|--|-----------------------|---------------------|
| Агаарын чанарыг сайжруулах бүс | Сайнцагаан сумын гэр хороолол, орон сууцны айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагууд хамаарна. (5, 6, 7, 8, 9 дүгээр баг) | 2679 | 1270 |

---oOo---

Сайнцагаан сумын агаарын чанарыг сайжруулах бүсийн байршлын тойм зураг

